



Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс



АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

ДАРХАН 2013

АГУУЛГА

- 1.1. Аймгийн газарзүйн байрлал, бизнесийн орчин
- 1.2. Аймгийн зах зээлийн багтаамж, цар хүрээ
- 1.3. Аймгийн дэд бүтцийн хөгжил байдал, харилцаа холбоо, зам гүүр, эрчим хүчний хангамж
- 1.4. Аж үйлдвэр
- 1.5. Барилга
- 1.6. Худалдааны салбарын өнөөгийн байдал

1. Аймгийн нутаг дэвсгэрт аж үйлдвэр, барилга, үйлчилгээний үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин, нөхцөл бололцоо


1.1. Газарзүйн байршил, хүн ам, бизнесийн орчин

Дархан-Уул аймаг нь 327,5 мян.кв.км нутаг дэвсгэртэй. Сэлэнгэ аймагтай хаяа нийлэн айлсаж оршиж байна. Нийт 92.7 мянган хүн амтай, засаг захиргааны нэгжийн хувьд 4-н сум, 26-н багтай. Нийт хүн амын 81,1 хувь нь хотод (хотын хүн амд аймгийн төв, нийслэл, тосгоны хүн амыг оруулан тооцсон болно. Аймгийн хувьд 18,9 хувь нь хөдөөд (хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөөгийн (баг) хүн амыг оруулан тооцсон) амьдарч байгаа нь хот аймаг болохыг харуулж байна. Хүн амынхаа тоогоор 75.6 мян хүн амтай Дархан сум тэргүүлж Шарын гол сум удаалдаг. 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 92735 хүн ам тоологдсоны 48.7 хувь буюу 45203 нь эрэгтэй, 51.3 хувь буюу 47532 нь эмэгтэйчүүд. Хүн амыг насны бүлгээр авч үзвэл 63.3 мянга нь хөдөлмөрийн насны, 25.6 мянга нь 14 хүртэл насны хүүхэд, 5.7 мянга нь өндөр настан байна.

1.2. Аймгийн зах зээлийн багтаамж, цар хүрээ

22.8 мянган өрхийн 83.1 хувь нь хот суурин газарт, 16.9 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байна. Эдийн засгийн үндсэн салбар нь Аж үйлдвэр, барилга, худалдаа үйлчилгээ.

Зураг. Аймгийн хүн амын тоо, хүн амын тооны өсөлтийн хувь



Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 42.0 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 35.5 хувиар тус тус өссөн байна.

2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 268.4 мянган толгой мал тоологдсоны дотор 0.4 мянган тэмээ, 11.3 мянган адуу, 35.6 мянган үхэр, 136.0 мянган хонь, 85.1 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо 2011 оныхоос 4.6 хувь буюу 11.6 мянган толгойгоор өслөө. Өвс Хадлан 60.1 мянган тн, гар тэжээл 265.3 тн, төмс, хүнсний

ногоо 56.8 тн бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 9.9 хувиар өсч, хураасан ургац үр тариа 14.3 хувиар буурсан байна.

Статистикийн бизнес регистрийн санд 2012 оны жилийн эцсийн байдлаар 2504 аж ахуйн нэгж бүртгэгдсэний 1699 буюу 67.9 хувь хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 805 аж ахуйн нэгж байгаагийн 46.6 хувь нь ажлаа огт эхлээгүй, 45.5 хувь түр зогссон, 5.1 хувь нь бүр зогссон, 2.9 хувь бусад янз бүрийн шатгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна.

Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 2011 оныхоос 34 хувиар нэмэгдсэн, боловч үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн эзлэх хувь 9.6 пүнктээр өсчээ.

Нийт аж ахуйн нэгжийн 34.5 хувь нь худалдааны салбарт, 6.6 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарт, 7.4 хувь нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 84.0 хувийг 1-9 ажиллагчидтай, 7.0 хувийг 10-19 ажиллагчидтай, 5.5 хувийг 20-49 ажиллагчидтай, 3.5 хувийг 50-с дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж эзэлж байна.


1.3 Аймгийн дэд бүтцийн хөгжил байдал, харилцаа холбоо, зам гүүр, эрчим хүчний хангамж

Аймгийн төв Дархан сум нь Улаанбаатараас 223 км-т оршдог. Орхон, Хонгор, Дархан, Шарын гол сумдын нутаг дэвсгэр дээгүүр төмөр зам дайран өнгөрдөг. Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон.


Аймгийн бүх сум үүрэн телефонд,, шилэн кабелд холбогдож интернет ашиглах боломжтой.

Аймгийн хэмжээгээр үүрэн телефоны оператор мобиком, скайтел, юнител, F-zone, G-mobile-н салбарууд үйлчилгээ үзүүлж байна.

Суурин утасны цэгийн тоо, Улс, бүс, аймаг 2007-2012 он



Авто машины тоо, 2007-2012 он



1. Аж үйлдвэрийн салбар

Дархан-Уул аймаг нь 1961 оноос Монгол Улсын барилгын түүхий эд, материалаар хангах зорилгоор аж үйлдвэрийн бааз хотын статустай байгуулагдсан. Манай аймаг хар төмөрлөгийн үйлдвэр, тоосго, бетон, цементийн болон хүнсний төрөл бүрийн үйлдвэрлэл, мах бэлтгэн боловсруулах, ургамлын тос боловсруулах үйлдвэр зэрэг голлох үйлдвэрүүдтэй үйлдвэрлэлийн цогцолбор хот болох төлөвлөгөөний дагуу хөгжиж байна.

Өнөөдрийн байдлаар жилд 100 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГазар, жилдээ 1.5 сая ширхэг нэхий боловсруулах хүчин чадалтай “Дархан нэхий” ХК, Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК, хөнгөн бетон, шохойн “Силикат” ХК, жилд нойтон аргаар 185 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Эрэл цемент” ХК, хүнсний манлай үйлдвэрлэгч “Дархан хүнс” ХК, “Дархан минж” ХХК зэрэг улсын чанартай томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний зэрэгцээ 2008 оноос гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай ургамлын тос боловсруулах “Монгол алтан тос”, нүүрс боловсруулах “Шарын гол энерго”, “Поликом” ХХК-ийн “Жаргалан хүнс” үйлдвэр “Дархан Меат Фүүдс” ХХК-ийн мах бэлтгэн боловсруулах үйлдвэр, “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Хүдэр олборлох баяжуулах үйлдвэр зэрэг томоохон үйлдвэр ажиллаж байна.

Манай аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт / 2005 оны зэрэгцүүлэх үнээр / 2012 онд 168250.9 сая төгрөг болж 2011 оноос 47.3 хувиар , 54004.9 сая төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

/ 2005 оны зэрэгцүүлэх үнээр /сая.төг

Салбарын ангилал	Оны үнээр		2005 оны зэрэгцүүлэх үнээр		2012/ 2011	2012/ 2011
	2011 он	2012 он	2011 он	2012 он		
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР	45956.2	75853.2	30380.9	78533.3	165.1	2.6 дахин
Нүүрс олборлолт	9863.5	12319.8	3934.4	4978.8	124.9	126.5
Бусад ашигт малт мал олборлолт	36092.7	63533.4	26446.5	73554.5	176.0	2.8 дахин
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР	84654.0	117888.1	71358.7	76653.5	139.3	107.4
Хүнс, ундаа үйлдвэрлэлт	7456.2	9676.6	5020.4	10765	129.8	2.1 дахин
Хувцас үйлдвэрлэлт	7115.6	9042.9	5979.3	6521.4	127.1	109.1
Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	126.3	196.7	88.7	49.5	155.7	55.8
Нийт лэл болон хэвлэх үйл ажиллагаа	22.7	28.9	38.3	69.5	127.3	181.5
Химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	98.0	141.3	118.8	154.1	144.2	129.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн	12227.3	8389.9	6662.9	4385.2	68.6	65.8
Төмөрлөгийн үйлдвэр	57607.9	90411.8	53450.3	54708.8	156.9	102.4
ЦАХИЛГААН,ДУЛААН, УС ҮЙЛДВЭРЛЭЛ	24029.4	25784.5	13090	13064.2	107.3	99.8
Дулаан, цахилгааны үйлдвэрлэлт	20278.0	21695.8	12121.1	12207.8	107.0	100.7
Усан хангамж	3751.4	4088.7	968.9	856.4	109.0	88.4
Нийт дүн	154639.6	219525.8	114829.6	168251.0	142.0	146.5

2012 оны Аж үйлдвэрийн салбарт нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 7.7 хувийг цахилгаан, дулаан ус үйлдвэрлэл, 46.7 хувийг уул уурхайн олборлолт, 45.6 хувийг боловсруулах салбарт үйлдвэрлэжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтэд Дархан сум 99.7 хувь, Хонгор сум 0.1 хувь, Шарын гол сум 0.2 хувийг үйлдвэрлэж байна. Сумуудын гол үйлдвэрлэл нь иргэдийг дулааны, цэвэр усаар хангах үйлдвэрлэл юм.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт нь 2012 онд 163164.0 сая.төг болж, 2011 оноос 35.5 хувиар өссөн байна. 2012 онд гадаад борлуулалт өмнөх оны мөн үетэй харьцуулхад 79,7 хувиар, дотоод борлуулалт 24,8 хувиар өсч байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт

САЯ.ТӨГ

Салбарын ангилал	Оны үнээр		2012/ 2011
	2011 он	2012 он	
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛАЛТ	34131.6	53150.3	155.7
Нүүрс олборлолт	11051.7	13718.7	124.1
Бусад ашигт малтмал олборлолт	23079.9	39431.6	170.8
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛАЛТ	63337.7	87758.1	138.6
Хүнс, ундаа үйлдвэрлэлт	7695	9427.4	122.5
Хувцас үйлдвэрлэлт	7509.9	11099.5	147.8
Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	176.8	163.4	92.4
Нийтлэл болон хэвлэх үйл ажиллагаа	30.7	149.1	4.9 дахин
Химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	64	198	3.1 дахин
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн	12133.5	11573.3	95.4
Төмөрлөгийн үйлдвэр	35727.8	55147.4	154.4
ЦАХИЛГААН,ДУЛААН, УС ҮЙЛДВЭРЛЭЛ БОРЛУУЛАЛТ	22979.9	22255.6	96.8
Дулаан, цахилгааны үйлдвэрлэлт	19793.3	18703.3	94.5
Усан хангамж	3186.6	3552.3	111.5
Нийт дүн	120449.2	163164.0	135.5



Аймгийн хэмжээнд нийт хүнс, хувцас, барилгын материал, уул уурхай гэсэн үндсэн бүтээгдэхүүний 100-д нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд байна. Үүнээс гол гэснийг аймгийн гол нэр төрөл болгон хүснэгтээр харууллаа. Хүнсний бүтээгдэхүүнийг аймагтаа болон зэргэлдээ бусад аймгийн сумдыг хангаж, хувцас, барилгын материалын, уул уурхайн бүтээгдэхүүний дотоод хэрэгцээндээ борлуулах буюу гадаадад экспортолж байна.


Дархан –Уул аймгийн аж үйлдвэрийн гол нэр төрлийн

бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

	нэгж	2011	2012	2012/ 2011
Тоосго	сая.шир	1.1	1.0	89.8
Гурил	тонн	9339.0	5033.7	53.9
Талх	тонн	1197.4	1188.9	99.3
Нарийн боов	тонн	626.7	595.4	95.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн	мян.литр	270.8	219.0	80.9
Өлөн гэдэс	м.гогц	101.7	88.5	87.0
Хиам	тонн	131.8	102.8	78.0
Архи	мян.литр	31.1	17.9	57.6
Хэвлэл	мхдх	737.3	1576.6	2.1 дахни
Цахилгаан	мян кв.цаг	216521.5	218469.6	100.9
Дулаан	мян.ккал	513.3	514.3	100.2
Цэвэр ус	мян.м куб	4402.2	3891.1	88.4
Нүүрс	мян.тонн	375.5	468.9	124.9
Нэхий дээл	шир	22519.0	9024.0	40.1
Хүүхдийн дээл	шир	3159.0	3308.0	104.7
Ажлын хувцас	шир	12152.0	8577.0	70.6
Эсгий шахай	шир	9262.0	21880.0	2.4 дахин
Савхин дээл	шир	2470.0	7448.0	3 дахин
Эсгий	мян м	21.2	9.4	44.4
Хүдэр	мян,тн	1110.5	2282.7	2.1 дахин
Хүдэр баяжмал	мян тн	484.4	663.5	137.0
Төмрийн бэлдэц	тонн	59793.6	59970.2	100.3
Цувимал	тонн	55426.1	57002.3	102.8
Элс хайрга	мян м.куб	15.0	34.3	2.3 дахин
Шохой	тн	11992.2	9000.0	75.0
Цемент	Мян.тн	91.4	54.2	59.3
Хөнгөн бетон	м. куб	14196.0	24432.0	172.1

Аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн диаграмм:





2012 онд манай аймаг Улсын ДНБ-ны 0,2 хувийг, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ны 2,0 хувийг үйлдвэрлэсэн байна.

Аж үйлдвэрийн салбарийн дүнгээр 2012 онд Аймгийн ДНБ –ны 37,4 хувь буюу 95275.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2011 онтой харьцуулахад 17353.6 сая төгрөг буюу 22.3 хувиар өсчээ.

2. Барилгын салбар

Хүснэгт 1. Аж үйлдвэр, барилгын салбарын нийт бүтээгдэхүүн /сая. төг/

	2009	2010	2011	2012
Дотоодын нийт бүтээгдэхүүн	127433.6	184626.9	201347.8	254746.4
Аж үйлдвэр, барилгын салбарын нийт гаргалт	45748.6	100252.4	77921.6	95275.1


2012 онд аж үйлдвэр, барилгын салбар 95275.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба энэ нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 37.4 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын нийт гаргалт нь 22.3 хувиар нэмэгдсэн байна.

2012 онд Дархан-Уул аймгийн барилгын салбарын 60 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 15.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 63.2 хувь буюу 9.9 тэрбум төгрөг нь барилга угсралтын ажил байна. Өнгөрсөн оноос гүйцэтгэсэн нийт ажлын хэмжээ 28.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Барилга угсралт, их засварын ажил, аймгийн дүн, сая төгрөг

	2008	2009	2010	2011	2012
Барилга угсралт, их засварын ажил	18945.5	10633.8	9044.4	12234.5	15703.7
Үүнээс: барилга угсралт	17394.1	8956.5	6756.3	8129.8	9928.5
их засвар	1551.4	1677.3	2288.1	4104.7	5775.2

Зураг 1. Барилгын салбарын гүйцэтгэсэн ажил, сүүлийн 5 жилээр, сая төгрөг



3. Худалдааны салбарын өнөөгийн байдал

Дотоод худалдааны салбар нь “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал”-ын дагуу дараахь 3 дэд салбараас бүрдэнэ. Үүнд:

1. Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ
2. Машин, Мотоциклээс бусад барааны бөөний худалдаа
3. Машин, Мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа

Статистикийн бизнес регистрийн санд бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 630 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 79.2 хувь нь хэвийн үйл ажиллагаа явуулж, 3.5 хувь нь үйл ажиллагаа бүрэн зогсоосон, 6.8 хувь нь түр зогсоосон, 6.8 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, үлдэх 3.7 хувь нь бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй гэсэн дүн мэдээ байна.

2012 онд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын орлого 55198.8 сая төгрөгт хүрч өмнөх оноос 5.3 хувиар өссөн байна.

2012 онд ДНБ оны үнээр 272.5 тэрбум төгрөг болж 2010 оныхоос 47.6 хувь буюу 87.9 тэрбум төгрөгөөр өслөө. Нэг хүнд ногдох ДНБ 2011 онд 2925.8 мянган төгрөгт хүрч

өмнөх оноос 983.2 мянган төгрөгөөр нэмэгдэв. Харин бөөний болон жижиглэн худалдааны салбар аймгийн ДНБ-ний 9.6 хувийг бүтээсэн байна.

Хүснэгт 2. Худалдаа үйлчилгээний салбарын нийт гаргалт, 2008-2012 он, сая төг

	2008	2009	2010	2011	2012
Аймгийн нийт гаргалт	127433.6	184626.9	201347.8	254746.4	353409.1
Худалдааны салбарын	30169.9	24615.6	52414.2	55198.8	96334.5
эзлэх хувь	22.3	19.3	28.4	27.4	27.3

Хүснэгт 3. Аймгийн болон худалдааны салбарын нэмэгдэл өртөг, оны үнээр, сая.төг


	2008	2009	2010	2011	2012
Аймгийн нэмэгдэл өртөг	79629.3	69108.3	91853.6	111527.6	142956.6
Худалдааны салбар	6348.8	6123.2	6939.4	8612.9	11579.5
эзлэх хувь	8.8	8.9	7.6	7.7	8.1

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, оны үнээр жилийн эцсийн байлаар

	2010	2011	2012	2011/ 2010%
Улсын дүн	2075546	3231266	4865172	150.6
Баруун бүс	70645.3	103753.6	123260.7	118.8
Хангайн бүс	55539.8	78059.9	104065.5	133.3
Төвийн бүс	176277.9	266192.5	312715.6	117.5
Дархан-Уул	52414.2	55198.8	96334.5	174.5
Зүүн бүс	28049.3	31924.3	32955.1	103.2
Улаанбаатар	1745033	2751336	4292175	156.0

Худалдааны салбарын нэмүү өртөг 2008 онтой харьцуулахад 79.5 хувиар өсч, өмнөх онтой харьцуулахад 28.2 хувиар өссөн байна.

Худалдааны нэг цэгт ноогдох хүний тоо, Улс, бүс, аймаг




Аймгийн болон худалдааны салбарын завсарын хэрэглээний бүтэц, 2010-2012 он хувиар


		Худалдааны салбар		
		2010	2011	2012
Завсрын хэрэглээ		100	100	100
Үүнээс	материал үр бордоо, тэжээл дэвсүүр, эм тарилга	2.1	2.6	1
	шатахуун, шатах, тослох материал	11.9	7.6	3.8
	сэлбэг хэрэгсэл	1	0.8	0.2
	эрчим хүч	4.9	6	3.1
	дулаан / уур ус хий /	4.5	3.1	1.3
	цэвэр бохир ус	2.5	1.1	0.3
	байшин барилга түрээсийн зардал	14.3	4.1	22.8
	машин тоног төхөөрөмжийн түрээсийн зардал	0.1	0	0.1
	- хөдөлмөр хамгааллын зардал	0	2.6	2.1
	тээвэр бэлтгэлийн ажиллагааны зардал	3.4	15	18.2
	гадны байгууллагаар үйлчлүүлсний төлбөр	1.6	2.4	1.9
	албан томилот	1.4	5.7	2
	холбооны зардал	2.2	2.2	1.3
	- интернэтийн зардал	0.1	0.1	0.4
	бичиг хэргийн зардал	0.2	0.1	0.2
	- ном, хэвлэлийн зардал	0	0	0
	засвар үйлчилгээ	3.7	3.9	2.1
	даатгалын зардал	0.4	0.8	0.6
	- ажиллагчдын сургалт, давтан сургалтын зардал	0.1	0.2	0.1
	- байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал	0	0.3	0
	зар сурталчилгааны зардал	1.1	7.4	20.1
бусад зардал	44.5	33.8	18.4	

Худалдааны салбарын засврын хэрэглээний бүтцийг харахад байшин барилга түрээсийн зардал хамгийн их хувийг буюу 22.8 хувийг эзэлж байна нь өмнөх оноос 18.7 функтээр өссөн байна.

Худалдааны салбарын завсарын хэрэглээний бүтэц, 2012 он , хувиар



Улаанбаатараас аймгийн төв хүртэлх замын урт, км-ээр



ДҮГНЭЛТ

Дархан -Уул аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн салбарт 2012 онд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 22, хувцас, оёдлын чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг 11, барилгын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 15, хэвлэх, эх бэлтгэх чиглэлээр 6, уул уурхайн олборлолт, хайгуулын чиглэлээр 5, цахилгаан дулаан, усан хангамжын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгж байнгын үйл ажиллагаатай ажиллаж байна.

Монгол Улсын засгийн газраас **Монгол Улсын загвар хот** болгохоор Дархан-Уул аймгийн хөгжлийн асуудлаар 3 томоохон шийдвэр гаргасан.

Нэгдүгээрт: Монгол Улсын засгийн газраас “Дархан газрын тос” төрийн өмчийн оролцоотой үйлдвэр байгуулах тогтоол гаргаж, барилгын ажил эхлэх гэж байна. Жилд 2 сая тонн нефть боловсруулах хүчин чадалтай нефтийн үйлдвэр 2015 онд ашиглалтанд орж, 600 гаруй ажлын байр шинээр бий болно.

Хоёрдугаарт: Монгол Улсын засгийн газрын 2012 оны 5-р сарын 23-ны өдрийн хуралдаанаар Дархан Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор шийдвэрлэж, ХХААХҮЯ-наас тусгай зөвшөөрөл авсанаар Дархан Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эхэлсэн. Энэ дагуу “Дархан Үйлдвэрлэл, технологийн парк”-ын нэгж болох 11 үйлдвэрийг сонгож, үйлдвэрүүдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж дууссан. Ингэснээр татварын болон гаалийн хөнгөлөлттэй бүс бий болж, хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдэж, томоохон үйлдвэрүүдээ цогцолбороор хөгжүүлэх боломж бүрдлээ. Өөрөөр хэлбэл “Нэхий” эдлэлийн үйлдвэрээ түшиглэн малын гаралтай түүхий эдийг боловсруулах, Төмөртэйн хүдрийн ордыг ашиглаж төмөр боловсруулах, шохой, ханын материал, барилгын үйлдвэрээ түшиглэсэн үндэсний хэмжээний үйлдвэр, технологийн парк цогцолборууд байгуулагдах юм.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 60 дугаар тогтоолоор Дархан үйлдвэрлэл технологийн паркийн байршлыг 1-р бүс буюу хүнд үйлдвэрийн, 2-р бүс буюу хуучин Дарханы үйлдвэрийн, 3-р бүс буюу сургалт, эрдэм шинжилгээний бүсэд хуваасан байна. Сургалт, эрдэм шинжилгээний бүсэд ямарваа нэгэн үйлдвэр байгуулахгүй, нийт шинээр төлөвлөгдөж байгаа болон өргөтгөх үйлдвэрүүдийг Дархан-Үйлдвэрлэл технологийн паркийн 1, 2 дугаар бүсэд хөгжүүлэхээр ажлын хэсгийн шийдвэр гарч, тус бүсэд “Нако түлш ХХК, “Балст бурнаст” ХХК, “Таван богд” группын гурилын үйлдвэр, ургамлын тосны “Монгол Алтан тос” гээд олон үйлдвэр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Мөн үйлдвэр нэмэгдэхийн хэрээр ур чадвартай буюу мэргэжлийн ажилчид шаардлагатай байна.

Дархан-Уул аймагт 2012 онд барилгын салбарын 70 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 15.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 36.8 хувь буюу 5.8 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Өнгөрсөн оноос гүйцэтгэсэн нийт ажлын хэмжээ 28.3 хувиар өссөн байна.

Худалдааны салбарын нийт борлуултын орлогод хүн амын тооны өсөлт, хүний хэрэглээний барааны нэр төрөл олширч байгаа нь өсөлтөд шууд нөлөөлж байна.

Монгол улсын Засгийн газраас Хөдөлмөр эрхлэлтийг жилээс жилд дэмжихтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажилласнаар жилээс жилд худалдааны цэгийн тоо нэмэгдэж, ажлын байрны тоо олноор бий боллоо.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ҮСХ-ны даргын 2011 оны 3-р сарын 17-ны өдрийн 01/30 тоот тушаалаар батлагдсан шинжилгээ судалгаа хийх арга зүйн зөвлөмж
2. Статистикийн салбарт мөрдөж ажиллах аргачлалын эмхэтгэл /МЭДЭЭЛЭЛ -3/ 2010 он

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

1. Монгол улсын Статистикийн эмхэтгэл-2012
2. Дархан-Уул аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга
3. Салбаруудын жил, улирлын мэдээнүүд

ТАНИЛЦУУЛГА ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Д.Жавзанлхам

С.Батцэнгэл